



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/581

Алтай хот

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Засаг даргын өргөн мэдүүлснээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтын газраа өмчлөхийг хүссэн хавсралтад дурдсан 2 иргэний газрыг гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлсүгэй.

2.Газраа өмчилж авсан иргэдийн өмчилсөн газрын мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг), өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээжүүлэхийг Улсын бүртгэлийн хэлтэс (Г.Чүлтэмжамц)-т тус тус даалгасугай.

3.Өмчлөх эрхээ холбогдох хууль тогтоомжийн дагуу эдэлж, өмчилж авсан газартаа газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хугацаанд нь хийлгэж байхыг газар өмчилж авсан иргэнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20.06.20 оны  
09 сарын 15-ны өдрийн 158 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

ГАЗАР ӨМЧИЛЖ АВЧ БАЙГАА ИРГЭДИЙН НЭР, ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/д	Ургийн овог	Эцэг /Эх/-ийн нэр	Өмчлөгчийн нэр	Регистрийн дугаар	Өмчилж авах газрын байршил	Өмчилж авах газрын төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ /м2/	Газрын үнэ		Газрын зориулалт
								Төгрөг		
1	Бэсүд	Ёндонжамц	Моломжамц	ДЮ04231116	Индэрт баг Сант 238 тоот	2553621	700.0	2100000.0		Гэр, орон сууцны хашааны газар (2205)
2	Харчин	Магсар	Гэрэлмаа	ДЮ63080301	Индэрт баг Сант 240 тоот	2553586	700.0	2100000.0		Гэр, орон сууцны хашааны газар (2205)

\_\_\_\_\_ооо\_\_\_\_\_